



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 01 сарын 19 өдөр

Дугаар 5102

Хэрлэн сум

Норовлин сумын Засаг даргад  
урамшуулал олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн албаны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1, 51 дүгээр зүйлийн 51.1.4 дэх заалт, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох тухай” 3 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2022 оны биелэлтээ иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаар 95,7 хувиар “тодорхой үр дүнд хүрсэн” гэж дүгнүүлсэн Норовлин сумын Засаг даргад мөнгөн урамшуулал олгосугай.

2.Батлагдсан төсөвтөө багтааж, үндсэн цалингийн 40 хүртэл хувиар тооцож, мөнгөн урамшуулал олгохыг сумын Засаг даргын Тамгын газрын даргад даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

231010097